


АШИГЛАЛТЫН ЗААВАР

АЕ-Н2


Бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө ашиглалтын заавартай сайтар танилцана уу.




БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНДСЭН АЖИЛЛАГАА

 Чийгшүүлэх товчлуур	Чийгшүүлэгчийг асаахын тулд “Чийгшүүлэх товчлуур”-ыг дарна. Энэ нь “Н” заагч гэрлийг асаах ба чийгшүүлэлт нь их түвшинд байна.
	Хоёр дахь удаа дарахад “L” заагч гэрлийг асаах ба чийгшүүлэлт бага түвшинд байна.
	Гурав дахь удаагаа дарахад чийгшүүлэгч “M” заагч гэрлийг асааж, унтлагын горимд шилжин бага түвшинд ажиллана. Уг гэрэл нь 3 секундын дараа унтрах болно.
	Дөрөв дэх удаагаа товшиход чийгшүүлэгч унтрах болно.
 Гэрлийн товчлуур	Чийгшүүлэгч “Н”, “L” чийгшүүлэлтийн горим дээр ажиллаж байх үед “Гэрлийн товчлуур”-ыг дарахад усны саван доторхи гэрэл асаж, өнгө нь автоматаар өөрчлөгдөнө.
	Хоёр дахь удаа товшиход тухайн асаж байгаа өнгийн гэрэл нь тогтмол болно.
	Гурав дахь удаа дарахад усны савны өнгө буцаад автоматаар өөрчлөгддөг төлөв рүүгээ шилжинэ.
	“Гэрлийн товчлуур” дээр 3 секунд жигд дарахад усны савны гэрэл унтарна.
Ус дууссаныг илтгэх анхааруулга:	
Ус дууссан үед 5 удаа улаан гэрэл анивчаад унтарна.	

АЖИЛЛАГААНЫ ЗААВАР



1. Төхөөрөмжийг тэгш гадаргуу дээр тавьсны дараа усны савны тагийг авах.
2. Усны саванд ус хийх.
3. Усны дээд түвшингийн тэмдэглэгээнээс хэтрүүлж ус хийхгүй байх.
4. Агаар гарах урсгалын хоолой руу ус хийхгүй байх. Энэ нь төхөөрөмжийг эвдрэл, гэмтэлд хүргэнэ.
5. Усны саванд амин тос /эфирийн тос/ хийж, өөртөө болон гэр бүлдээ үнэрт эмчилгээ хийх.
6. Усны савны тагийг хааж, цахилгаанд залгаж, чийгшүүлэгчийг ажиллуулах.



Усны саваыг 3 өдөр болгоод
1 удаа цэвэрлэж хэвшээрэй.

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ЗАГВАР:	AE-H2	ХЭМЖЭЭС: ЖИН:	180*180*258 1.035 КГ
ЧАДАЛ:	20-25 W	БАГТААМЖ:	2.5 Л
ЧИЙГШҮҮЛЭХ ЧАДАЛ:	L: 100±25%ml/h H: 150±25%ml/h	АЖИЛЛАХ ЦАГ:	Дээд түвшиндээ 13 цаг орчим
МАТЕРИАЛ:	PP (Хүчлийн эсрэг)	ХҮЧДЭЛ:	100-240 VAC 50/60 Hz

ЦЭВЭРЛЭГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭ

АНХААРУУЛГА

Төхөөрөмжийг цэвэрлэхээс өмнө цахилгааны хүчдэлээс салгасан эсэх, усны саванд ус үлдсэн эсэхийг шалгана уу. Энгийн цэвэрлэгээ нь эрүүл ахуйн зохистой ажиллагаа болон алдаа мадаггүй ажиллах урьдач нөхцөл юм. Уг чийгшүүлэгч нь ямар нэг тусгай хэрэгсэл шаардахгүйгээр цэвэрлэх боломжтой бүтээгдэхүүн.

- Усны савны ёроолын голд байх бөөрөнхий хэсэг нь мананцар үүсгэгч гол бүрэлдэхүүн тул түүнийг 7 хоног бүр зөөлөн хөвөн даавуугаар цэвэрлэнэ. Хэрэглээнээс хамаарч 7 хоногт хэдэн ч удаа цэвэрлэж болно.

- Усны савны доторхийг идэмхи, шүлтлэг чанартай цэвэрлэгээний бүтээгдэхүүн хэрэглэх, хатуу зүлгүүр, алчуураар үрж арчиж болохгүй.

- Хэрэв усны саванд усны чанараас үүдэлтэй шохойжсон давхарга г.м үүсвэл, лимоны хүчил эсвэл винегер ашиглан цэвэрлэж болно.

Нэмэлт

1. Чийгшлийн хувь хэмжээ өндөр байх нь янз бүрийн бичил организмыг дэмждэг.
2. Хэрэв чийгшлийн түвшин 65 хувиас их болвол чийгшүүлэгчийг унтраа.
3. Төхөөрөмжийг хэрэглээгүй үедээ усны саваыг хуурай, цэвэр байлгана.
4. Усны саван дахь ус цэвэр бус, байнгын цэвэрлэгээ хийгддэггүй бол бичил биет үржих таатай нөхцөл үүсэж, төхөөрөмж ажилласнаар агаарт цацагдаж, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх байдал үүсч болзошгүй.
5. 3 хоног бүр 1 удаа цэвэрлэгээ хийж байна уу.